

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОРООДЫН НИЙГМИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН АЧААЛЛЫГ ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*М. Од-Эрдэнэ
Магистр оюутан*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

oderdene62@gmail.com

*Н. Нямдорж
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн
их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

nyamaa89@gmail.com

***Хураангуй:** Төрийн захиргааны анхан шатны нэгж болох хорооны хүн ам, нэн ялангуяа хүүхэд, гэр бүл, зорилтот бүлэгт хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хорооны нийгмийн ажилтны ажил үйлчилгээний хэрэгжилт, ажлын ачаалал, өнөөгийн нөхцөл байдлыг судлан, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх боломжийг судлах шаадлага бий болж байна. Хорооны нийгмийн ажилтан нь хэн нэгэнд тохнолдсон бэрхшээлийг даван туулах, нөөц боломжийг нь бодит боломж болгоход нь туслах зорилготой мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн бөгөөд хувь хүн, гэр бүлд тулгарч буй асуудал, тэдний амьдарч буй орчны нөхцөл байдлыг судлан, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх, бүлэг олон нийтэд чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах зэргээр мэргэжлийн үйлчилгээг үзүүлдгээрээ онцлог гэдгийг энэхүү судалгаанаас харж болно.*

***Түлхүүр үг:** Төрийн алба, нийгмийн ажилтан, ажлын ачаалал*

УДИРТГАЛ

Төрийн албан хаагчид нь ард түмэндээ үйлчлэхдээ хүний эрх, эрхэм чанарыг хүндэтгэдэг, хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бусдыг мэдэрч ойлгодог, хувь хүний болон хамт олны давуу талыг түшиглэж ажилладаг, тэднийг чадавхжуулж, эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх,


хүн төвтэй төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхэд чиглэдэг.

Хүүхдийн тусламжийн утас 108-д 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1588 мэдээлэл бүртгэгдэж үүнээс 1278 мэдээллийг шийдвэрлэж, 310 мэдээллийг хорооны Хамтарсан багийн хяналтад авч ажиллаж, 2024

оны байдлаар дуудлага мэдээллийг 80,4% тай шийдвэрлэсэн. Энэхүү дуудлага мэдээллийг хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж, шийдвэрлэдэг.

Баянзүрх дүүргийн харьяаллын хүүхдүүд үйлчлүүлсэн бол, 2024 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 1310 хүүхэд, үүнээс 268 буюу 20,4% нь Баянзүрх дүүргийн хүүхдүүд хамгааллын үйлчилгээ авсан байгаа нь Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг нэмэгдүүлж байгааг дараах судалгаанаас харж болно.

Баянзүрх дүүргийн хэмжээнд Хүүхдийн Тусламжийн Утас 108-д ирсэн дуудлага мэдээлэл (Сүүлийн 4 жилээр)



Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн нийт тоо 2024 онд 1326 үүнээс 424 буюу 32% нь Баянзүрх дүүргийн харьяаллын хүүхдүүд үйлчлүүлсэн бол, 2024 онд түр хамгаалах байр, нэг цэгийн

үйлчилгээний төвөөр нийт 1310 хүүхэд, үүнээс 268 буюу 20,4% нь Баянзүрх дүүргийн хүүхдүүд хамгааллын үйлчилгээ авсан байгаа нь Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг нэмэгдүүлж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Судалгааны агуулгын хүрээ:

Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг тодорхойлох судалгаанд одоо ажиллаж байгаа 24 хорооны нийгмийн ажилтнуудыг хамруулан, тэдний оролцоотойгоор ажлын байранд ажлын ачааллыг тодорхойлох, бүсчилсэн байдлаар нэг өдрийн зураглал гаргуулах, фокус бүлгийн ярилцлагаар хэсэгчилсэн байдлаар судалгаа авсан.

Судалгааны зорилго:

Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороодын нийгмийн ажилтны албан тушаал, чиг үүргийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах, ажлын ачааллыг тодорхойлох судалгааг хийж үнэлэх, дүн шинжилгээ хийх, судалгаанд үндэслэн хорооны нийгмийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, ажлын үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах, ажлын ачааллыг бууруулах, тэнцвэржүүлэхэд оршино.

Судалгааны зорилт:

- Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг тодорхойлох судалгааны аргачлалыг боловсруулах, батлуулах

- Ажлын байранд очиж нийгмийн ажилтны ажил үйлчилгээнд судалгаа хийх
- Цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, дүгнэлт, санал гаргах

Судалгааны аргачлалд тулгуурлан, хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллыг бодитой гаргаж ирэхийг зорьсон бөгөөд албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үйлчилгээнээс гадна албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй ажил үйлчилгээ, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээнд зарцуулж буй хугацааг тооцоолох, судлах зорилго тавин ажилласан.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршдог.

Нийгмийн ажилтны олон улсын холбооноос 2014 онд "Нийгмийн

ажил нь нийгмийн өөрчлөлт, нийгмийн хөгжил, хүмүүсийн нэгдмэл байдал, чадваржуулалтыг хөхиүлэн дэмждэг практик үйл ажиллагаанд суурилсан мэргэжил бөгөөд шинжлэх ухааны салбар мөн" гэж тодорхойлсон байдаг.

Хорооны нийгмийн ажилтны болон түүний эрх, үүрэг, үзүүлэх үйлчилгээний талаар "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", "Хүүхэд хамгааллын тухай", "Халамжийн тухай хууль" хуулиуд болон тэдгээрийг дагалдан гарсан журмуудад тусгайлан заасан байдаг.

Хорооны нийгмийн ажилтнууд албан тушаалын тодорхойлолт, түүнийг хэрэгжилтийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Чиг үүрэг	Хэрэгжилт
Албан тушаалын тодорхойлолтын зорилго	Нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, холбогдох хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгаа хийх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хорооны Засаг даргад дэмжлэг үзүүлэх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.	Нийгмийн ажилтнууд албан тушаалын тодорхойлолтын үндсэн 4 зорилтын 19 чиг үүргийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан тушаалын тодорхойлолтыг гол чиглэл болгон ажлаа төлөвлөн ажиллаж байна.

Зорилт-1	Нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан холбогдох хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Нийгмийн ажилтан нь анхан шатанд холбогдох хууль тогтоомжийг иргэд олон нийтэд цахимаар, мэдээллийн самбар, арга хэмжээгээр дамжуулан сурталчлан ажиллаж байна.
Зорилт-2	Нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд хорооны Засаг даргад дэмжлэг үзүүлэх	Засаг даргыг ажлын чиг үүргийн хүрээнд өдөр тутмын мэдээллээр ханган ажиллаж байна.
Зорилт-3	Судалгаа хийх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, төрийн үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн бүлгийн төрөлжсөн судалгааг гарган, судалгаанд үндэслэн олон талт арга хэмжээг төлөвлөн ажилладаг.
Зорилт-4	Байгууллага нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Нийгмийн ажилтан нь албан тушаалын тодорхойлолтоос гадна холбогдох хууль, журмаа үүрэг хүлээж, мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг.

“Ажлын ачаалал” гэдэг нь хүний ажил үүргийг гүйцэтгэх явцад мэдэрч буй физик, сэтгэлзүйн болон оюуны хүч зарцуулалт, тухайн ажлын хүндрэлийн түвшинг хэлдэг ойлголт юм. Өөрөөр хэлбэл, ажлын ачаалал гэдэг нь:

- Хийх ажлын хэмжээ
- Ажлын төвөгтэй байдал
- Ажлыг гүйцэтгэх хугацааны шахалт
- Сэтгэл зүйн дарамт, стрессийн түвшин зэрэг хүчин зүйлсийн нийлбэр үр дүн юм.



Хэт их ачаалал нь ядаргаа, стресс, бүтээмж буурах, эрүүл мэндийн асуудал үүсгэж болдог. Харин зохистой түвшний ачаалал нь өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлж чаддаг.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ




Хороодын нийгмийн ажилтнуудаас 7 үзүүлэлтээр

ерөнхий байдлын судалгааг авахад 24 нийгмийн ажилтан хамрагдсан.

Судалгааг танилцуулбал:



Нийт нийгмийн ажилтны 50% нь 1 жил хүртэлх хугацаанд ажиллаж байна гэж хариулсан нь нийгмийн



ажилтнуудыг цаашид чадавхжуулах, ажлын байранд нь дадлагуулах ажлуудыг хийх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнуудын 70.8% нь 10.000 буюу түүнээс дээш хүн амтай хороонд ажиллаж байгаа нь нэг хүнд ногдох хүн амын тоо өндөр байгааг харуулж байна.

Нийт судалгаанд хамрагдсан хороодын нийгмийн ажилтнуудын 29,2% нь дан гэр хороололд, 45,8% нь байр, гэр хороолол хосолсон холимог хороонд ажиллаж байна.

Нийгмийн ажилтнуудын 58,3% нь заримдаа ажлын 8 цагтаа ажлаа багтаан ажлаа гүйцэтгэдэг гэж хариулсан бол, 29,2% нь ажлын цагтаа ажлаа хийж гүйцэтгэж чаддаггүй, дөнгөж 12,5% нь л ажлын цагтаа багтаж ажил үүргээ гүйцэтгэх боломжтой гэж хариулсан байна.

5. “Та өдөрт хамгийн их давтамжтай, цаг хугацаа зарцуулдаг ажил үйлчилгээг нэрлэнэ үү” гэсэн нээлттэй асуултад хариулсныг эрэмбэлбэл:

1. Хамтарсан багийн ажил үйлчилгээ (ХТУ 108, цагдаагийн байгууллагаас, бусад эх сурвалжаас ирсэн дуудлага мэдээллээр ажиллах, НБҮ хийх, айлаар орж, гэрээр орсон тэмдэглэл хөтлөх, кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх, кейс файл бүрдүүлэлт гэх мэт мэргэжлийн үйлчилгээнүүд)
2. Хүүхэд, гэр бүлийн асуудлаар зөвлөгөө, үйлчилгээ авахаар ирсэн иргэдтэй уулзаж, зөвлөгөө мэдээлэл өгөх
3. Захиргааны шинжтэй бусад ажлууд, бичиг цаас цэгцлэх, баримт бичиг боловсруулах
4. ХТУ 108-д мэдээлэл оруулах
5. Судалгаа гаргах зэргийг хамгийн их цаг хугацаа зарцуулдаг гэж хариулжээ.

Энэ байдлаас дүгнэхэд, хорооны нийгмийн ажилтнууд ажлын ихэнх цагийг хамтарсан багийн ажил буюу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд зарцуулдаг байна.

Хорооны хамтарсан баг нь гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, шуурхай таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг иргэдэд хамгийн ойрын цэгээс үзүүлэх зохион байгуулалтын хэлбэр бөгөөд Засаг даргаар ахлуулсан, хорооны нийгмийн ажилтан, цагдаагийн хэсгийн байцаагч, халамжийн, боловсролын, эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр салбар дундын хамтын ажиллагааг ханган ажилладаг.

Практикт хуулиар үүрэг хүлээсэн албан хаагчдын тэгш оролцоо хангагдахгүй байгааг энэхүү судалгаанд оролцогчдын 45,8% нь “Хамтарсан багийн ажлын 90-ээс дээш хувийн ажлыг гүйцэтгэж байгаа” гэсэн судалгааны дүн харуулж байна.

Нийгмийн ажилтан нь хүчирхийллийн хохирогч болон бие махбод, сэтгэл санааны хувьд ихээхэн хохирол амссанаас удаан хугацааны дарамт хүчирхийллээс үүдэлтэй өвөрмөц зан үйл, сэтгэл зүйн хувьд тогтворгүй иргэдтэй ажилласны улмаас шууд буюу шууд бус байдлаар стресс, сэтгэл зүйн хямралд өртдөг нь ажлын сэтгэл ханамжид нөлөөлдөг.

Хорооны нийгмийн ажилтны ажлын ачаалал


Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллын ерөнхий төлөв байдлыг

гаргахдаа баримт бичгийн болон талбарын судалгаанд шинжилгээ хийхээс гадна Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Хорооны хамтарсан багуудаас авсан тоон мэдээллүүдийг голлох эх сурвалж болгон ашиглалаа.


Тус дүүрэг нь Нийслэлийн хамгийн их хүн амтай, томоохон дүүргийн нэг бөгөөд хорооны нэг нийгмийн ажилтанд ногдох өрх, хүн амын тоог бусад дүүргүүдтэй харьцуулахад өндөр байгааг дараах судалгаанаас харж болно. (43 хорооны нийгмийн ажилтнаар тооцсон болно).



Нийгмийн ажилтанд ногдох
 өрхийн тоог
 бусад дүүргүүдтэй харьцуулсан
 байдал



Нийгмийн ажилтны ерөнхий
 төлөв байдал








- Хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцох хувь
- 10000-аас дээш хүн амтай хороонд ажиллаж буй нийгмийн ажилтны эзлэх хувь
- Гэр хороололд ажиллаж буй нийгмийн ажилтны эзлэх хувь

Судалгаанаас дүгнэхэд, нийгмийн ажилтан нь ажлын ачаалал өндөр байгааг хүн амын болон өрхийн тооноос харагдаж байна.

Хорооны нийгмийн ажилтан нь Хамтарсан багийн нарийн бичгийн дарга (кейс менежер)-ээр ажилладаг бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, багийн гишүүдийг арга зүй, мэдээ, мэдээллээр ханган ажилладаг.

Хорооны нийгмийн ажилтны ажлын ачааллын төлөв байдлын талаарх судалгааг авч, ачааллыг бууруулах талаарх санал авсан.





“Нийгмийн ажилтны ажлын ачааллыг үүсгэхэд нөлөөлж буй ямар хүчин зүйл байна гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад хариулсныг агуулгаар нь багцлан танилцуулбал:

- Олон хэлтэс, албадаас албан бичиг их ирж, судалгаа хугацаа тулгаж байнга авч байна.
- Хамтарсан багийн гишүүд оролцоо байхгүй байна. Хамтын ажиллагаа муу байна.
- Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй ажлууд их байна.
- Нийгмийн ажилтан тусдаа өрөөгүй тул хүндрэлтэй байна.
- ХТУ108, НАМС программ тус тусад мэдээлэл оруулдаг тул хугацаа их зарцуулж байна.

“Нийгмийн ажилтны ажлын ачааллыг бууруулахад таны санал юу байна вэ?” гэсэн асуултад хариулсныг агуулгаар нь багцлан танилцуулбал:

- Албан тушаалын тодорхойлолтын дагуу ажил үүргээ гүйцэтгэдэг байх

- Хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага тооцдог байх, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- НАМС программ гацалт ихтэй, программын шинэчлэл хийх
- Нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх
- Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй зарим ажлуудыг шилжүүлэх
- Анхан шатанд нийгмийн ажилтан хүн амд хөгжил, хамгааллын үйлчилгээг хүргэхэд ачаалалтай байна.
- Нийгмийн ажилтны зэрэг дэвийг ахиулах зэрэг саналуудыг гаргасан.

Өдөр тутам гүйцэтгэдэг ажлуудыг нэгтгэн (эхний 5 ажил үйлчилгээ) их ачааллаас бага ачаалал руу эрэмбэл дараах байдалтай байна. Энэ нь хорооний нийгмийн ажилтны ажлын нэг өдрийн зураглалыг харах боломжийг давхар гаргаж байгаа юм.




ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Баянзүрх дүүргийн хороодын нийгмийн ажилтны ажлын ачааллыг тодорхойлох судалгааг судалгааг 2025 оны 03 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд судалгааны ажлыг дүүргийн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр авч дууссан.

Судалгаанд одоо ажиллаж байгаа 24 хорооны нийгмийн ажилтнуудыг хамруулан, ажлын байранд очих, нэг өдрийн ажлын байрны зураглал гаргах, фокус бүлгийн ярилцлага хийх зэргээр судалгаа хийсэн.

Судалгааны үр дүнг танилцуулбал:



Дээрх судалгаанаас харахад хорооны нийгмийн ажилтан өдөрт 8 цагтаа ажил үүргээ бүрэн хангалттай гүйцэтгэдэггүй, илүү цагаар ажилладаг нь харагдаж байна.

Мөн нэг өдрийн ажлын цагийн 87,5%-ийг Хамтарсан баг, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд, 25%-ийг төлөвлөгөө боловсруулж, тайлан, илтгэх хуудас гаргах, албан бичгийн төсөл боловсруулах, холбогдох баримт бичгийн ажлуудад, тухайн 7 хоногт хэрвээ сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах бол ажлын цагийн 25%-ийг зарцуулдаг байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэлд тоон болон чанарын боловсруулалт хийсний үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хорооны нийгмийн ажилтан нь албан тушаалын тодорхойлолтоос гадна албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй ажил үйлчилгээнд 7 хоногт 18,1 цаг зарцуулдаг нь ажлын цагийн 45,1%-ийг эзэлж байгаа тул ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.
2. Нийгмийн ажилтан нь албан тушаалын тодорхойлолтыг чиглэл болгон ажиллахаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй

тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиар үүрэг хүлээж, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох журмын хүрээнд мэргэжлийн үйлчилгээг хүргэдэг тул, хариуцлагатай, цаг хугацаатай, шуурхай ажиллахыг шаарддаг тул ажлын ихэнх цагийн мэргэжлийн үйлчилгээнд зарцуулдаг.

3. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, шуурхай таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг иргэдэд хамгийн ойр цэгээс үзүүлэх үүрэгтэй. Хорооны хамтарсан багийн гишүүдийн тэгш оролцоо хангалтгүй, хамтарсан багийн үйл ажиллагааны 90-ээс дээш хувийг хорооны нийгмийн ажилтан хариуцан ажиллаж байгаа нь дээрх судалгааны үр дүнгүүдээс харагдаж байна. Нэг өдрийн ажлын байрны зураглалаар гаргаж ирсэн судалгаанд хамгийн их ачаалалтай давтамж ихтэй ажил үйлчилгээг Хамтарсан багийн ажил үйлчилгээ гэж нэрлэсэн байгаа нь нийгмийн ажилтнуудын ажил үүргийн ихэнх хувийг мэргэжлийн үйлчилгээ эзэлж байгааг харуулж байна.
4. Баянзүрх дүүрэг Нийслэлийн хамгийн их хүн амтай бөгөөд нэг нийгмийн ажилтанд дунджаар

2439 өрх, 8927,7 хүн ам ногдож байгаа нь бусад дүүргүүдийн нийгмийн ажилтнуудтай харьцуулахад өндөр байгааг дээрх судалгаанаас харж болно. Энэ нь хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудалд нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

САНАЛ

Хорооны түвшинд өгөх

санал:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйл, “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж, хамтарсан багийн гишүүдийн тэгш оролцоог нэмэгдүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан ажиллах;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна” гэж зааснаар Хороодын Засаг дарга нар нийгмийн ажилтнуудыг ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, боломжтой бол тусад нь өрөөтэй болгох зэргээр бүх боломжоор дэмжин ажиллах;
- Нийгмийн ажилтны үндсэн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод хамаарахгүй бусад ажлын үүрэг чиглэл

өгөхдөө ажлын ачааллыг харгалзан үзэх;

Дүүргийн удирдлагуудад өгөх санал:

- Нийгмийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Нийгмийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй зарим ажил үйлчилгээг бусад ажилтан руу шилжүүлэх. Тухайлбал,
- Хотын хөгжлийн индексийг нийгмийн ажилтан, зохион байгуулагч нар өөрсдийн чиг үүргийн дагуу судалгааг гаргаж, программд шивж оруулах, ерөнхийд нь зохион байгуулагч нарт хариуцуулан өгөх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажил нь хорооны зохион байгуулагчийн албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үйлчилгээ тул зохион байгуулагч нарт хариуцуулан өгөх; (Зарим хороодын нийгмийн ажилтнууд хариуцдаг)
- Нийгмийн ажилтнууд ХТУ108, НАМС, Хотын хөгжлийн индекс, шаардлагатай тохиолдолд ХАМС зэрэг программууд руу орж ажилладаг тул компьютер гацах асуудал гардаг. Мөн нийгмийн

ажилтан нөхцөл байдлын үнэлгээ, хамтарсан багийн хурлын шийдвэр, холбогдох материалуудыг скайнердах, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг дуудлагаар ажилласан тухай мэдээлэл, үнэлгээг скайнердаж оруулах зайлшгүй шаардлагатай байдаг тул компьютер, скайнер, принтерийг сайжруулах;

- Интернетийн хурдыг сайжруулах;
- Бичгийн цаасыг хангалттай өгөх.

НОМ ЗҮЙ

1. *Гэр бүлийн хүчихийлэлтэй тэмцэх тухай хууль. УИХ. 2022 он*
2. *Хүүхэд хамгааллын тухай хууль. УИХ. 2024 он*
3. *Төрийн албаны тухай хууль. УИХ. 2019 он.*
4. *Баянзүрх дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн ХТУ 108-д ирсэн дуудлага, мэдээллийн танилцуулга. 2024 он. БЗД.*
5. *ХТУ 108-аас авсан мэдээлэл. 2024 он. ХГБХХЕГ.*
6. *Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс. 2024 он*
7. *Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын мэдээлэл. 2024 он*
8. *2024 оны болон 2025 оны Хамтарсан багийн гишүүдийн ирцийн 1 улирлын мэдээ. 2025 он. УБ хот. БЗД.*
9. *ГБХЗХХ-ийн мэдээлэл. 2024 он. УБ хот*
10. *2024 оны Дүүргийн Засаг даргын захиармжийн биелэлт. 2025 он*